МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 04 өдөр № 26/27 Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
орлох этгээдийг түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2026 оны 15 дугаартай дүгнэлт, Капитрон банкны 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ/40 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Төлөөлөн удирдах ердийн гишүүн Батцэнгэлийн Үүрцайхбаатарыг 2026 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болгон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасантай холбогдуулан чөлөөлөгдсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдээр Энхтүвшингийн Төрболдыг Б.Үүрцайхбаатарын хэрэгжээгүй үлдсэн бүрэн эрхийн хугацаагаар томилсугай.
3. Э.Төрболд нь энэ тогтоолын 2-т заасан бүрэн эрхийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж, Б.Үүрцайхбаатарын гишүүнчлэл бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны бүрэлдэхүүнд орж, ажиллахыг дурдсугай.
4. Э.Төрболдтой нууцын гэрээ байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай.
5. Э.Төрболдод бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн холбогдох журмын дагуу батлагдсан төсвийн хүрээнд цалинг тооцож олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
6. Энэ тогтоолд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх холбогдох хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар зохих хууль тогтоомжид заасан журмын дагуу хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэл хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул)-нд даалгасугай.
7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (Ч.Хашчулуун)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,

МИК ХОЛДИНГ ХК
УЛААНБААТАР ХОТ

М.МӨНХБААТАР